



**МОНГОЛБАНК  
СУДАЛГАА, СТАТИСТИКИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ОРЛОГО, ЗАРДЛЫН СУДАЛГАА /ТУР ОПЕРАТОР/**

---

**Хураангуй**

Төлбөрийн тэнцлийн статистикийн аялал жуулчлалын дансны орлого, зардлын гүйцэтгэлийг тооцохын тулд гадаадын жуулчдаас авах дундаж орлого болон Монгол иргэдийн гадаадад аялж буй дундаж зардлыг тодорхойлохоор энэхүү түүвэр судалгааг гүйцэтгэв.

Түүвэр судалгаанд Монгол Улсад аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй 42 аж ахуйн нэгжээс асуулгын аргаар тоон мэдээллийг авч, нэгтгэн тооцсон бөгөөд судалгааны гол үр дүнгээс дурдвал, гадаадын жуулчид манай улсад дунджаар 9 хонох хугацаандаа 1,928 ам.долларыг зарцуулдаг бол манай иргэд гадаад улсад аялал жуулчлалын зорилгоор 7 хонох хугацаандаа 2,007 ам.долларыг зарцуулдаг байна.

Энэхүү үр дүнг өмнөх судалгааны дүнтэй харьцуулбал, орлогын дүн 2015 оны дунджаас 5%-иар буурч, зардлын дундаж 2014 оны дүнгээс 24%-иар өссөн үзүүлэлт байна. Үүнийг БОАЖЯ-тай хамтран 7-8 сард агаараар болон газраар зорчигч гадаад, дотоодын жуулчдаас авах судалгааны үр дүнтэй харьцуулан дахин тооцож, түүвэр судалгааны эцсийн үр дүнг гаргана.

---

## I. ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Төлбөрийн тэнцлийн статистикийн хамрах хүрээ, мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд 2017 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-тай хамтран “Монгол улсын аялал жуулчлалын орлого, зардлын судалгаа /тур оператор/”-г асуулгын аргаар зохион байгууллаа. Судалгааг зөвхөн тур оператор компаниудаас авсан нэг талын мэдээлэлд үндэслэсэн тул судалгааны үр дүнг бусад түүвэр мэдээллийн эх сурвалжтай харьцуулан тооцож, баталгаажуулсны дараа статистик тооцоонд ашиглана.

## II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 2.1. Судалгааны зорилго

Төлбөрийн тэнцэл дэх жуулчлах зорилготой аяллын үйлчилгээний орлогыг Хил хамгаалах ерөнхий газар (ХХЕГ)-аас ирүүлдэг жуулчдын тоон мэдээлэлд тохируулга хийн Монголбанкнаас 2011, 2015 оны судалгаагаар тооцсон дундаж орлогын дүнгээр, аяллын зардлыг 2014 онд тооцсон дундаж зардлын дүнгээр тус тус үржүүлэн тооцож байна.

Гадаад, дотоодын инфляцийн түвшин ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан дундаж орлого, зардал тогтмол өөрчлөгддөг тул энэ төрлийн түүвэр судалгааг 2-3 жилийн давтамжтай гүйцэтгэж, тооцооллыг шинэчлэх шаардлагатай байдаг. Энэ удаагийн судалгаагаар багцын аяллын дундаж орлого, зардлыг шинэчлэн тооцохын зэрэгцээ бусад зардлын дүн, зарцуулалтын мэдээллийг олж авахыг зорилоо. Мөн яамны зүгээс аялал жуулчлалын салбарын бодлогын шийдвэрт дэмжлэг болгох зорилгоор гадаадын жуулчдын манай улсад аялах шалтгаан, сэтгэл ханамж, тур операторуудад тулгамдаж буй асуудлын талаар санал зөвлөмжийг агуулсан асуултуудыг тусгасан нь энэ удаагийн судалгааны онцлог байлаа.

### 2.2. Ерөнхий мэдээлэл

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл дэх аяллын үйлчилгээ



Төлбөрийн тэнцлийн статистикаас харахад, Монгол улсын аялал жуулчлалын үйлчилгээний орлого буюу гадаадын иргэдээс хүлээн авсан орлогын хэмжээ нь манай иргэдийн гадаадад аялахдаа зарцуулсан зардлаас бага, цэвэр дүнгээр 2016 онд 166 сая ам.долларын алдагдалтай буюу ДНБ-ий 1.5%-тай тэнцэх хэмжээний гадаад валютыг аялал жуулчлалд зарцуулсан тооцоо байна.

Монгол Улсын хилээр нэвтэрсэн жуулчдын статистикаас үзвэл 2015-2016 оны хооронд гадаадын жуулчдын тоо 10%-иар өссөн (2011 онтой харьцуулбал 3%-иар буурсан) байна. Харин дотоодын жуулчдын гарах урсгал 2014 оноос 27%-иар, 2011 оноос 35%-иар тус тус өсчээ.

### Хүснэгт 1. Гадаадын жуулчдын орох урсгал<sup>1</sup>

Улс	2011	2015	2016
АНУ, Канад	12344	13443	15927
Австрали, Шинэ Зеланд	4889	4005	5040
БНСУ	34512	36546	48567
БНХАУ	104898	79961	71816
ХБНГУ	6554	7267	8534
ИБУИНВУ	5062	5072	5258
ОХУ	80868	57716	65962
Франц	6781	6892	8408
Япон	11907	15109	17571
Баруун европ	12374	9459	12659
Бусад	25548	34829	36299
<b>Нийт</b>	<b>305737</b>	<b>270299</b>	<b>296041</b>

### Хүснэгт 2. Дотоодын жуулчдын гарах урсгал


Улс	2011	2014	2016
АНУ, Канад	5959	9175	10914
БНСУ	34720	40004	56243
БНХАУ	1038515	1141999	1218357
Европ	11778	18080	19202
ОХУ	181337	194479	498065
Тайланд	3724	4347	3724
Япон	5354	10564	14680
Бусад	93860	33243	29594
<b>Нийт</b>	<b>1375247</b>	<b>1451891</b>	<b>1850779</b>

### 2.3. Түүврийн оновчтой хэмжээ

Түүврийн эх олонлогийг 2016 онд Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоо, гадаадад аялсан Монгол жуулчдын тоо харгалзан 378,436; 1,921,272<sup>2</sup> гэж үзэж, хамгийн бага оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон тооцоолоход харгалзан 384; 384 гарч байна.

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Энд,  $t$  = Студентийн  $t$  тархалтын критик утга;  $w$  = түүврийн тодорхой асуултад хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол хэмжээг ашигладаг;  $N$  = эх олонлогийн хэмжээ;  $\Delta$  = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг  $\Delta$  хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал.



Өгөгдөл	Утга	Тайлбар
<b>t</b>	1.96	95%-ийн итгэх магадлалын түвшин
<b>w</b>	0.5	Тогтмол утга
<b>N</b>	378,436	Эх олонлог: 1 жилд аялсан жуулчдын тоо
<b>Δ</b>	0,05	Алдааны хязгаар
<b>n</b>	384	Оновчтой түүврийн хэмжээ

### 2.4. Түүврийн хэмжээ, шинж чанар

Түүвэр судалгааны хүрээнд 2017.04.17-ноос 2017.05.26-ны өдрийн хооронд 105 тур оператор компанитай холбоо тогтоож, үүнээс 42 тур оператор<sup>3</sup> компанийг (21,446 жуулчинд үйлчилгээ үзүүлсэн) сонгож мэдээлэл цуглуулсан. Түүврийн хэмжээ нь 2016 онд хилээр нэвтэрсэн болон хилээр гарсан нийт жуулчдын 1%-ийг эзэлж байна. Үүнээс зөвхөн гадаадын жуулчид хүлээн авах тусгай зөвшөөрөлтэй 27, дотоодын жуулчид гадаадад аялуулах эрхтэй 11, олон улсын аялал жуулчлалын эрхтэй 4 тур операторууд судалгаанд хамрагдсан байна.

<sup>1</sup> ХХЕГ-ын мэдээ (хувийн, жуулчин)

<sup>2</sup> ХХЕГ-ын мэдээ (албан, хувийн, жуулчин, суралцах)

<sup>3</sup> АЖХолбооны мэдээлснээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг 120 тур оператор байдаг, үүнээс 35% нь түүвэрт хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан тур оператор компаниудын хувьд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа дунджаар 7 жил байгаа нь харьцангуй туршлагатай, эх олонлогийг төлөөлж чадахуйц байна.

### Ш. СУДАЛГААНЫ НЭГДСЭН ҮР ДҮН

#### 3.1. Аяллын дундаж зардал


Хүснэгт 3. Түүврийн үр дүн, улсаар (ам.доллар)

Улс	Дундаж хоног	Аяллын дундаж зардал
АНУ, Канад	10	3006
Австрали, Шинэ Зеланд	7	1505
БНСУ	6	1208
БНХАУ	5	804
ХБНГУ	15	1355
ИБУИНВУ	8	1467
ОХУ	7	1050
Франц	9	1741
Япон	4	1121
Зүүн Ази	6	1115
Баруун европ	10	1541
Бусад	4	750
<b>Нийт</b>	<b>9</b>	<b>1600</b>

**Гадаадын жуулчдын зардал.** Манай улсад аялж буй гадаадын жуулчдын зардал улс орноосоо хамаарч ялгаатай гардаг бөгөөд энэ судалгаагаар тур оператор компаниас дунджаар **1600 ам.долларын** багц аяллын үйлчилгээ авсан байна.

Гадаадын жуулчид манай улсад дунджаар 9 хоногийн хугацаатайгаар аялдаг бөгөөд ХБНГУ, бусад европын жуулчид хамгийн их хугацаатайгаар зорчдог байна. Жуулчдын аяллын дундаж хугацаа, зардлыг улс орноор харуулсан дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 3-аас харж болно.

Дүрслэл 2. Зардлын бүтэц, улсаар (ам.доллар)




Аяллын дундаж зардлын хувьд АНУ, Канад, Австрали, Европын жуулчид хамгийн өндөр байдаг бөгөөд Азийн улс орнуудын жуулчдын зардал харьцангуй бага байна. Жуулчдын тур оператор компанид төлсөн зардлын бүтцийг харвал зочид буудал, зоогийн газарт 31%, тээврийн үйлчилгээнд 27%, бусад үйлчилгээ (тухайн тур операторын урсгал зардал, ашиг, бусад дагалдах үйлчилгээ)-нд 21%, хөтчийн цалинд 11%, үлдсэн 4% нь үзвэр үйлчилгээний тасалбар, бусад энтертайнмент үйлчилгээнд тус тус зарцуулагддаг байна.

Гадаадын жуулчдын багц аяллын дүнгээс бусад зардал дунджаар **328 ам.доллар**, зарцуулалтын бүтцийг авч үзвэл барааны худалдаанд 48% буюу 157 ам.доллар, аяллын багийн урамшуулалд 25% буюу 82 ам.доллар, үзвэр бусад үйлчилгээнд 26% буюу 85 ам.долларыг аяллын үеэр зарцуулсан тооцоо гарч байна.

Хүснэгт 4. Багц аяллын бусад зардал (ам.доллар)

Улс	Нийт
Австрали, Шинэ Зеланд	186
АНУ, Канад	788
БНСУ	258
БНХАУ	94
ИБУИНВУ	226
ХБНГУ	301
Франц	216
Япон	70
Зүүн Ази	374
Баруун европ	229
Бусад	400
<b>Нийт</b>	<b>328</b>

Дүрслэл 3. Бусад зардлын бүтэц (ам.доллар)



Хүснэгт 5. Өмнөх судалгаатай харьцуулсан байдал\*<sup>4</sup>(ам.доллар)

Улс	2015*	2017	2017/2015*
АНУ, Канад	3009	3334	11%
Австрали, Шинэ Зеланд	2048	1833	-11%
БНСУ	1565	1536	-2%
БНХАУ	1440	1132	-21%
ХБНГУ	2259	1683	-26%
ИБУИНВУ	1907	1795	-6%
ОХУ	1081	1378	27%
Франц	1338	2069	55%
Япон	1357	1449	7%
Зүүн Ази	1530	1443	-6%
Баруун европ	1914	1869	-2%
Бусад	2412	1078	-55%
<b>Нийт</b>	<b>2033</b>	<b>1928</b>	<b>-5%</b>

Монголбанк, АЖҮТөвтэй хамтран 2015 онд хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулбал, гадаадын жуулчдын Монгол Улсад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ 5%-иар буурсан, энэ нь өнгөрсөн жилүүдийн төгрөгийн эсрэг ам.долларын чангаралттай холбоотой байна. Тухайлбал, жуулчид хамгийн их ирдэг 3 дугаар улирлын төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2015 онд 1,988 байсан бол 2016 оны мөн улиралд 8%-иар өсч 2,155 болсон байна. Тэгвэл 2017 оны эхний 5 сарын байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2,452 хүрч өмнөх оны мөн үеэс 22%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Дотоодын жуулчдын зардал.** Судалгаанд хамрагдсан тур оператор компаниудын дийлэнх нь Монгол аялагчдыг БНХАУ, ОХУ-д аялуулах үйлчилгээг эрхэлсэн байх бөгөөд судалгааны асуулгын үр дүнгээр, манай иргэд дунджаар 7 хоногийн аяллаар **1184 ам.доллар** зарцуулдаг тооцоо гарч байна. Тур оператораар үйлчлүүлэн АНУ, Канад, Европын улс орнуудад аялахад хамгийн их зардал гаргадаг бол ОХУ-ын Буриад улс луу Байгаль нуур үзэх, Итгэлт хамбад мөргөх зорилгоор аялахад хамгийн бага зардлаар аялдаг байна (Хүснэгт 6).


Дээрх зардлын зарцуулалтыг тооцвол, аяллын дундаж зардлын 67%-ийг тухайн аялсан улсад зарцуулдаг, үүнээс зочид буудал зоогийн газрын үйлчилгээнд 52%, үзвэр үйлчилгээний төлбөрт 22%, тухайн улсын хөтөч, орчуулагчид 13%, үлдсэн 13%-ийг тухайн улсын тээврийн үйлчилгээнд тус тус зарцуулдаг байна (Дүрслэл 4).

<sup>4</sup> Багцын аяллын дүн, багцаас бусад зарцуулалтын дундаж дүнг оруулсан болно.

Хүснэгт 6. Түүврийн үр дүн, улсаар (ам.доллар)

Улс	Хугацаа	Багцын үнэ	Гадаад луу төлсөн
АНУ	8	3265	86%
АНЭУ	7	1650	23%
БНСУ	4	400	68%
БНХАУ	5	516	55%
Европ	11	2099	78%
Малайз	9	770	88%
ОХУ	4	77	69%
Тайланд	6	912	45%
Бусад	6	969	69%
<b>Нийт</b>	<b>7</b>	<b>1184</b>	<b>67%</b>

Дүрслэл 4. Зардлын бүтэц, улсаар (хувиар)



Хүснэгт 7. Бусад зардлын бүтэц, улсаар (ам.доллар)

Улс	Нийт	Бараа худалдаа	Үзвэр үйлчилгээ	Бусад
АНУ	500	80%	4%	16%
АНЭУ	1500	67%	20%	13%
БНСУ	105	100%	0%	0%
БНХАУ	1174	68%	20%	13%
Европ	500	80%	4%	16%
Малайз	400	75%	25%	0%
ОХУ	848	69%	19%	12%
Тайланд	1500	67%	20%	13%
Бусад	880	74%	15%	12%
<b>Нийт</b>	<b>823</b>	<b>75%</b>	<b>14%</b>	<b>11%</b>

Жуулчид нь тур оператор компанид төлсөн аяллын багц үнээс гадна дунджаар **823 ам.долларыг** бусад төрлийн үйлчилгээнд зарцуулдаг бөгөөд бүтцийг авч үзвэл барааны худалдаанд 75% буюу 621 ам.доллар, үзвэр үйлчилгээнд 14% буюу 116 ам.доллар, бусад үйлчилгээнд 11% буюу 87 ам.долларыг аяллын үеэр зарцуулсан байна (Хүснэгт 7).

Хүснэгт 8. Өмнөх судалгаатай харьцуулсан байдал<sup>5</sup>

Судалгааны нэр	Түүврийн хэмжээ	Дундаж зардал
Жуулчдын зардлын судалгаа - 2005	1190	<b>521</b>
Жуулчдын зардлын судалгаа - 2014	375	<b>1622</b>
Аялал жуулчлалын зардлын судалгаа 2017*		<b>2007</b>

Энэ төрлийн түүвэр судалгааг өмнө нь Монголбанкнаас 2005, 2014 онуудад зохион байгуулж байсан бөгөөд үр дүнгийн харьцуулалтыг Хүснэгт 8-д үзүүлээ. 2017 оны судалгааны үр дүнг 2014 онтой харьцуулахад Монгол жуулчдын гадаадад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ 24%-иар өссөн үзүүлэлттэй байна.


Зардлын дундаж дүн өсөлттэй харагдаж байгаа нь зөвхөн тур оперотороор дамжин үйлчлүүлж буй багц аяллын зардлыг тооцсонтой холбоотой, өөрөөр хэлбэл өмнөх судалгаа нь багцын болон хувийн аяллын дүнг нэгтгэн тооцсон дүн юм. Иймд судалгааны эх сурвалжийг дахин нэмж хувийн аялагчдын дунд судалгаа явуулж үр дүнг нэгтгэн тооцох, баталгаажуулах шаардлагатай.

<sup>5</sup> Багцын аяллын дүн, багцаас бусад зарцуулалтын дундаж дүнг оруулсан болно.

### 3.2. Жуулчдын сэтгэл ханамж

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь Монголын уламжлалт зан заншил, байгаль ан амьтан үзэх зорилгоор ирсэн бөгөөд тур операторуудын үйлчилгээг 72% нь сайн, 25% нь маш сайн, 3% нь хангалттай гэж үнэлсэн. Улмаар манай улсад аялсан сэтгэл ханамжийн түвшингээ нийт аялагчдын 26% нь маш сайн, 46% нь сайн, 27% нь хангалттай гэж үнэлсэн ба дахин ирж аялах талаараа 89% нь тийм, 11% мэдэхгүй гэдгээ илэрхийлсэн байна.

Дүрслэл 5. Гадаадын жуулчдын аялах зорилго юу вэ?



Монгол Улсын аялал, жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхэд дараах тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэсэн саналыг тур операторууд өгсөн. Үүнд:

- i. *Олон улсын нислэг, тээврийн хүрэлцээгүй байдлыг сайжруулах.* Гадаад, дотоодын нислэгийн хуваарь төлөвлөгөөт хугацаанаас өөрчлөгддөг, хүрэлцээ муу, хангалтгүй байдаг тул аяллын эрчимтэй үед нэмэлт нислэгийн тээврийн үйлчилгээг зохицуулах;
- ii. *Тур оператораас бусад аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг үйлчилгээний газруудын стандартыг сайжруулах.* Жуулчны бааз, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээ хангалтгүй байдаг;
- iii. *Салбарын нэгдсэн бодлого сул.* Гадаадын улс орнуудад сурталчлах, үйл ажиллагаа зохион байгуулах зэрэгт салбарын нэгдсэн бодлого хангалтгүй;
- iv. *Нийтийн тээврийг сайжруулах.* Улаанбаатар хотын автобус, орон нутгийн галт тэрэг, нислэгийн хуваарь болон чиглэлүүдийн талаар жуулчдад зориулсан мэдээллийн төвийг бий болгох;
- v. *Угаалгын өрөө, хогийн сав.* Хотод болон жуулчны баазуудын ариун цэврийн өрөөг сайжруулах, шинээр бий болгох, хогийн сав хангалттай байрлуулах, шүршүүрийн халуун усыг шийдвэрлэх;
- vi. *Бусад бүтээн байгуулалтын санал.* Музейн тайлбарыг Англи хэл дээр хийх, сүм, хийдүүдийг засварлах, бусад төрлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох.

## IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар Монгол Улсад аялсан гадаадын жуулчдын дундаж зардал болон гадаадад аялсан Монгол жуулчдын дундаж зардлыг шинэчлэн тооцоолсон нь цаашид төлбөрийн тэнцэл, аялал жуулчлалын статистикийн чанарыг сайжруулах ач холбогдолтой боллоо.

Монголд ирсэн жуулчдын хувьд ирсэн улс орноосоо хамаарч зардлууд нь харилцан адилгүй дунджаар 9 хоногт 1,928 ам.доллар зарцуулдаг ба энэ нь Монголбанкнаас 2015 онд хийсэн судалгааны үр дүнгээс 5%-иар буурсан үзүүлэлт, харин гадаадад аялсан Монгол жуулчид дунджаар 7 хоногт 2,007 ам.доллар зарцуулдаг бөгөөд энэ нь 2014 оны судалгааны дүнгээс 24%-иар өссөн үзүүлэлт байна. Судалгааны үр дүнг 2017 оны 3 дугаар улиралд хийгдэх судалгааны үр дүнтэй харьцуулах, баталгаажуулах шаардлагатай гэж үзэж байна.